АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 2
1.1. Төслийн нэр 2
1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллага 2
1.3. Төслийн байршил, тойм зураг 2
1.4. Төслийн төлөвлөлт, ажиллах хүчин 4
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 6
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 9
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ 10
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 11
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 12
ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ . 12
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 13
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 14
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 14
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 16
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1 Байгаль орчны товч тодорхойлолт 6
Хүснэгт №2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №1 төслийн талбайн байршлын тойм зураг 3
Зураг №2 Төсөл хэрэгжих талбайн зураг 4

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Ган төмөрлөгийн үйлдвэр” төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллага

“Дөлтүшиг” ХХК

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9019006014


Регистрийн дугаар: 5016673

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг, үйлдвэрийн байранд.

1.3. Төслийн байршил, тойм зураг

Энэхүү төсөл нь Багануур дүүргийн 3-р хороонд хэрэгжиж байна.

Зураг №1 Төслийн талбайн байршлын тойм зураг



Зураг №2 Төсөл хэрэгжиж буй талбайн зураг



1.4. Төслийн төлөвлөлт, ажиллах хүчин

Үйлдвэрийн талбай нь дараах барилга байгууламжуудаас бүрдэнэ. Үүнд:

1. Оффис болон лабораторийн барилга
2. Цахилгаан хангамжийн станц
3. Усан хөргөлтийн байгууламж
4. Түүхий эдийн талбай
5. Бэлэн бүтээгдэхүүн хадгалах, ачилт хийх талбай

6. Ажилчдын амрах байр, хоолны газар
7. Ногоон байгууламж, зам талбай
8. Харуул хамгаалалт бүхий үйлдвэрийн хашаа зэрэг болно.

Хүснэгт №1 Техник эдийн засгийн үндэслэлийн нэгдсэн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Хэмжээ
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн, хүчин чадал			
1	Иржгэр гадаргуутай даацын ган туйван MNS G JIS 3112:2002 стандартын SD390, SD345 ангилал Ф:10, 13, 16, 19, 22, 25 мм	Тн/жил	30,000.0
	Гөлгөр гадаргуутай угсралтын ган туйван (Катанка) SR235 ангилал: ф6.5, 8, 10, 12 мм	Тн/жил	20,000.0
	Нийт		**50,000.0**
Үндсэн түүхий эдийн хэрэгцээ			
2	Хаягдал хар төмөр, бэлдэц	Тн/жил	55,000.0
	Кварцит, электрод	Тн/жил	625,000.0
	Ферросилицин 75%	Тн/жил	500.0
	Ферромарганец 75%	Тн/жил	900.0
	Шингэн шил	Тн/жил	220.0
	Хүчилтөрөгч	$М^3$/жил	70,000.0
	Пропан	$М^3$/жил	3,000.0
Технологийн материалууд			
3	Тосолгооны материал	Тн/жил	185.0
	Сэлбэг материал	Тн/жил	975.0
	Цахилгаан сэлбэг	Тн/жил	340.0
Нийт үйлдвэрлэлийн үзүүлэлт			
4	Суурилагдсан цахилгаан чадал	квт	12,500.0
	Технологийн усны хэрэгцээ	Тн/хоног	25.0
	Үйлдвэрийн ажиллах жилийн хоног	Хоног	210.0
Үйлдвэрийн ажиллах хүч			
5	Ажиллах хүчний хэрэгцээ	Хүн	250
	Захиргааны ажилчид	Хүн	17
	Үйлдвэрийн ажилчид	Хүн	233

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт №1 Байгаль орчны товч тодорхойлолт

№	Үзүүлэлтүүд	Утга
1	Уур амьсгал	Баганаар дүүрэгт зуны улиралд Хэрлэн голын хөндий уруудсан, хүйтний улиралд хөндий өгссөн агаарын урсгал ноёрхдог тул уур амьсгалын увьд монгол орны бусад газартай харьцуулахад зун нь халуун бус чийглэгдүү, хүйтэвтэр мужид байрлана. *(Г.Намхайжанцан, 2002).* Жилийн дундаж температур -5°С, өвөл нь хүйтэн, хамгийн хүйтэн сар XII, I сар, үнэмлэхүй бага температур -39.5°С хүрнэ. Хамгийн халуун сар VII сар, үнэмлэхүй их температур 32.1°С хүрдэг. Үнэмлэхүй их, бага температурын зөрөө Монгол орны бусад хэсэгтэй ижил маш өндөр. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 100-120 хоног. Агаарын даралт өндөр, жилийн ихэнх хоног дунджаар жилд 250 хоног цэлмэг байдаг. Жилийн дундаж салхины хурд 3.4м/сек, баруун баруун хойд зүгийн салхи голлох бөгөөд салхины хүч IV, V-р сард хамгийн хүчтэй байна. Жилийн дундаж харьцангуй чийгшил 70-75% хүрч хамгийн хуурай хаврын улиралд 45- 55% байна. Энэ бүс нутагт хуурай өдөр 25-30 өдөр тохиолдож байхад 40-50 өдөр нь 70%-иас дээш чийгтэй байдаг. Хур тунадас жилдээ 250-300 мм байдаг ба энэ нь жил бүр харилцан адилгүй байдаг *(Г.Намхайжамцан)*. Хур тунадасны 95-97% нь дулааны улиралд, 75-80% нь зуны улиралд ордог ерөнхий зүй тогтолтой. Хэнтийн уулсаар унах хур тунадасны 80-85% нь зуны улиралд орох бөгөөд жилдээ 350-450 мм хур тунадас ордог байна.
2	Газарзүйн тогтоц	Баганаар дүүрэг нь Монгол Улсын нийслэлийн 9 дүүргийн, алслагдсан 3 дүүргийн нэг бөгөөд засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотод харьяалагдах боловч байрлалын хувьд Төв, Хэнтий аймгийн хил дээр баруун талаараа Төв аймгийн Баяндэлгэр, хойд талаараа Төв аймгийн Мөнгөнморьт, зүүн талаараа Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумуудтай хиллэдэг, хойноосоо урагш сунасан 620.2км^2 нутаг дэвсгэртэй Хэрлэн голын баруун эрэг дагуу байрлана.
3	Геологийн тогтоц	Баганаар дүүрэг нь академич Ш.Цэгмидийн тодорхойлсноор физик газарзүйн мужлалын хувьд Хангай Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн муж, Хэнтийн захын хэсгийн тойрогт хамаарагдана. Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэнгийн тодорхойлсноор байгалийн бүс бүслүүрийн хувьд бэсрэг уулын хэв шинж бүхий ойт хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд ландшафтын хувьд тайгын нутгаас говь, хуурай хээрийн нутаг руу шилжих завсрын хэв шинжтэй байна. Далайн түвшнээс дээш 1,276.0-1,400.0 метр өндөрт өргөгдсөн Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт байрлах, эх

№	Үзүүлэлтүүд	Утга
		газрын эрс тэс уур амьсгалтай, зун богино, төдий л халуун биш, өвөл нь хүйтэн урт, баруун, баруун хойд зүгийн салхи ноёлдог чийглэгдүү хүйтэвтэр бүс нутаг бөгөөд Номхон далайн ай савд багтах Хэрлэн голын ус хураах талбай байрладаг. Хамгийн өндөр цэг нь дүүргийн нутаг дэвсгэрийн хойд зүгт орших Баян-өндөр уул 1,689.3 метр, хамгийн ойр орших өндөр цэг нь Овоот уул 1,718.1 метр хамгийн нам цэг нь Хуцаагийн голын хөндий 1,330.0 метр, баруун хойноосоо зүүн урагш намссан хөндий юм.
4	Хөрсөн бүрхэвч	Дөлтүшиг ХХК-ийн хэрэгжүүлж буй “Ган төмөрлөгийн үйлдвэр” нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн өргөргийн бүсшилийн хар хүрэн ба хөрсний дэд бүсийн Мааньтын 4-р тойргийн хойд захын хэсгийн нутгийг хамарна *(Үндэсний атлас, 2022 он).* Хөрс нь үржил шим харьцангуй сайн, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрс тархсан байна. Уг хөрс нь хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, бага зэрэг карбонаттай, ялзмагийн агууламжаар баялаг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор, калийн агууламж хангалттай байна.
5	Ургамлан нөмрөг	Монгол орны ургамал газар зүйн мужлалаар Баганаар орчим нь Евразийн хээрийн их мужийн Хэнтийн уулын тайгын тойрогт хамаарна *(Өлзийхутаг, 1989).* Баганаар орчим нь уулс, бэсрэг уулс, хотгор, хотос, тойром, цав толгод, ухаа гүвээ ээлжлэн солигдох бөгөөд голлох ургамалжлын хэв шинж нь үетэн-шарилжилт, алаг өвст-хялганат, уулын хээр тал хөндийгөөр чулуусаг алаг өвс-шарилж-крыловын хялганат, агь, ботууль, алаг өвст-хялганат хээрийн бүлгэмдэл зонхилсон байна. Ган төмөрлөгийн үйлдвэрийн талбайд байгалийн ургамал үндсэндээ мөхсөн байна. Их доройтож, талхлагдсан газар тул зөвхөн талхагдлын цөөн хэдэн ургамлууд буюу хашаа дагаж ургасан лууль, таван салаа, царван ургасан байна. Тус талбайд 1980 оноос хойш тасралтгүй 40 жил үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлсэн, хүний хөлийн нөлөөлөлд бүрэн автсан.
6	Гадаргын ус	Баганаар дүүргийн нутаг дэвсгэрт голын сүлжээ сайн хөгжсөн. Гадаргын усны сүлжээний нягтшил 1км^2 талбайд ногдох голын урт газар бүрд харилцан адилгүй, 0-930 метрийн хооронд хэлбэлзэж хамгийн их урсцын бүрдэлт голын эхэнд өндөр уулын бүс болох Хэнтийн нуруунд байна. Номхон далайн сав газарт уртаараа нэгт ордог Хэрлэн гол Баганаар дүүргийн нутаг дэвсгэрээс 10-14 км зайтай, хойноос урагш чиглэж, хэд хэдэн салаалан урсдаг байна. Хэрлэн мөрөн Хэнтийн нурууны зүүн сугаас эхэлж, Далай нуур, Амар мөрнийг дамжиж Номхон далайд цутгадаг. Сав газрын морфологийн нөхцөл харилцан адилгүй тул урсцын хэмжээ дэд сав газар бүр өөр өөр байна. Урсцын хэмжээ 18.3мм/жил-19.6мм/жил байна. Хэрлэн Баяндэлгэр харуулын мэдээгээр дундаж урсац 1951-1975 оны дунджаар 31.8м^3/сек,

№	Үзүүлэлтүүд	Утга
		1980 онд 11.4м^3/сек болтлоо буурч, 2011-2014 оны дундаж урсац 22.9м^3/сек байна. Улсын хил хүртэл 1,090 км урт, ус хураах сав газрын талбай 116,455.0 км^2 бөгөөд усны дундаж унал км тутамд 1.2м болно. Дулааны улиралд бүх урсцын 80% урсаж өнгөрдөг. Үүний 30% хаврын улиралд урсаж өнгөрнө. Номхон далайн ай савын гол мөрний бүх талбайн 54%-ийг Хэрлэн голын усны сав эзэлдэг. Голын сав газарт 6 аймаг, 42 сумын иргэд, байгууллагын унд, усны хэрэглээ, малын бэлчээрийн усан хангамж, сав газарт байгаа ашиглалтын 104, хайгуулын 167 тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн усны хэрэглээгээ хангаж байдаг. Багануур станцын мэдээнээс харахад Хэрлэн голын усны чанар, найрлага нь эрс өөрчлөлт багатай. Анионуудаас гидрокарбонатын ион, катионуудаас кальцийн ион дангаараа зонхилсон, бүх тохиолдолд цэнгэг, маш зөөлөн, бохирдол багатай буюу “Гадаргуугийн усны цэврийн зэргийн ангилал”-аар “цэвэр”, бага зэрэг бохирдолтой ангилалд байна. Эрдэсжилт болон хатуулгийн хэмжээ сүүлийн жилүүдэд багасах хандлагатай байна.
7	Гүний ус	Төслийн талбайд нийт 4 ширхэг гүний худагтай бөгөөд унд ахуй болон технологийн хэрэгцээнд ашиглаж байна.
8	Амьтан	Төсөл хэрэгжиж буй талбай нь хүн амын суурьшлын бүс болсон байгаа тул талбай орчимд жигүүртэн шувуудаас өөр амьтны төрөл, зүйл байхгүй байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Дөлтүшиг” ХХК-ийн ган төмөрлөгийн үйлдвэр нь Багануур дүүргийн 3-р хороо, үйлдвэрийн бүсэд байрлаж байна.

- Үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд хаягдал төмөр тээвэрлэх, ачиж буулгах, ил задгай байснаар хөрс техноген нөлөөлөлд өртсөн ба машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс бохирдсон байгаа нь лабораторийн шинжилгээний үр дүнгээр илэрхийлэгдэж байна.
- Үйлдвэрийн талбайд хатуу хучилттай зам талбай байгуулаагүй, сул шороон хөрс байна. Иймд үйлдвэрийн түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүн тээвэрлэх том оврын машин механизмын явалтаар хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд орж байна.
- Үйлдвэрийн талбай нь дүүргийн үйлдвэрийн бүсэд байрлаж байгаа тул байгалийн ургамал бүрхэвч талхлагдан үгүй болж, хөл газрын ургамлаар солигдсон байна.
- Үйлдвэрийн талбайн ойр орчимд гадаргын ус байхгүй. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, чанарт үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй байна.
- Дөлтүшиг ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг үйлдвэрийн ажилчдад мөрдүүлэн, хянах хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн болон талбайн инженертэй бөгөөд ажилчид хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг бүрэн өмсөж, үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.
- Тус үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд 200 хүнийг улирлын чанартай ажлын байраар хангаж, орон нутгийн төсөвт оруулах орлого, татварын орлого болон ажлын байр нэмэгдэх зэрэг нийгэм эдийн эерэг нөлөөтэй байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан журам, мөн сайдын 2014 оны 4-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримтлан боловсрууллаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө багтсан бөгөөд төслийн 2026 оны БОМТ-ний ажилд нийт **5,727,000.0₮** зарцуулахаар төлөвлөв.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ									
1	Хорт хийн ялгарлаас агаарын бохирдол үүсэх	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэлтэй холбоотойгоор зуухны янданд шүүлтүүр суурилуулах	Шатаах зуухууд	ш	-	3	Дотоод төлөвлөлтөөр	2026 онд	Холбогдох хуулиуд
2	Тоосжилт	Талбайн тоосжилтыг дарах зорилгоор байнгын усалгаа хийх	Талбайн хэмжээнд	Гүний худгаас усны машинаар усалгааг хийх				2026 онд Хуурайшилттай үед	-
Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө									
3	Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх	Талбайд болон ойр орчинд олон салаа зам гаргахгүй нэгдсэн сүлжээг сайжруулж, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, хуучин тэмдэг тэмдэглэгээг засаж сэлбэх	Төслийн талбайд	ш	100 000₮	5	500 000₮	V сард	
4		Үйлдвэрийн хашаанд хийгдсэн явган замыг засаж сэлбэх	Төслийн талбай	ш	2,500,000.0₮	-	2,500,000.0₮	VI сард	
НИЙТ ЗАРДАЛ					**3,000,000.0₮**				

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг[1]	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	**2**	**3**	**4**	**5**	**6**	**7**	**8**	**9**
1	Улиас тарих	Ажилчдын байрны урд хэсгээр	Ногоон байгууламж нэмэгдүүлэх	ширхэг	200 ш	5,000.0₮	1,000,000.0₮	IX сард	MNS 6260:2020
Нийт зардал			**1,000,000.0₮**						

ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

[1] *Зах зээлд зарагдаж байгаа дундаж үнээр тооцлоо.*

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Гал түймэр	Галын аюулын талаар анхааруулга самбарыг эзэмшлийн объект тавих. Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг тогтмол шалгах	Төслийн талбай	500,000.0₮	Иж бүрдэл	500,000.0₮	VI сард	MNS 4970:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ. MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16.1.7
2	Аюулгүй ажиллагаа алдагдах	Жолооч нарт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Жолооч нарт	Өдөр бүр ажилд гарахын өмнө			2026 онд тогтмол	
	НИЙТ ЗАРДАЛ			**500,000.0₮**				

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг/5 жил)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Ахуйн	Хатуу хог хаягдлыг тогтмол ачуулах	Төслийн талбай	Сард	Дүүргийн ТҮК-тэй байгуулсан гэрээний дагуу тогтмол ачуулах			Хуваарийн дагуу	
	НИЙТ ЗАРДАЛ				**-**				

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, мян. төг	Нийт зардал, сая. төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар, бохирдлын мониторинг							
1	Хорт хий, ББ-ууд: Тоос /PM10, PM2.5/ CO2 SO2 NO2	Ачих буулгах хэсэг, замын орчноос	Жилд 2 удаа	2 цэгээс	72,500.0₮	145,000.0₮	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 4885:2025/
Хөрсний чанар, бохирдлын мониторинг							
2	Бичил биетний тоо (1гр-д) Колититр Cl.perferringens титр	Хогийн цэгийн орчмоос	Жилд 2 удаа	3 цэгээс	25,000.0₮	150,000.0₮	Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүдийн нэр төрөл /MNS 3985 - 1987/
3	Хүнд металлууд /Pb, Cd, Cr, Ni, Zn/	Ачих буулгах хэсэг, зам,	Жилд 2 удаа	3 цэгээс	35,000.0₮	210,000.0₮	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис,

		машин засварын газрын орчмоос					элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019
4	Агрохимийн үзүүлэлт	Сул чөлөөтэй талбайгаас	Жилд 2 удаа	3 дээж	25,000.0₮	150,000.0₮	
Усны чанар, бохирдлын мониторинг							
5	Усны химийн ерөнхий шинжилгээ	Гүний худгаас	Жилд 2 удаа	4 дээж	71,500.0₮	572,000.0₮	Ундны усны чанарын стандарт, MNS 0900:2005
Дүн					Жилд: 1,227,000.0₮		

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг	Хариуцах хяналт тавих
1	Ажилчдын дунд аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Жилд 2 удаа	Дотоод төлөвлөлтөөр		Талбайн ерөнхий инженер
Зардал			-		

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион газар
Орон нутгийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	-	Орон нутгийн иргэдийн нийтийн хурлын танхим, төсөл хэрэгжүүлж буй газар
БОУАӨЯ-ны ХБОБНГ-т	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	

Хүснэгт №2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	3,000,000.0₮
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,000,000.0₮
3	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
6	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500,000.0₮
7	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	1,227,000.0₮
	2026 оны нийт зардал	5,727,000.0₮